



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

**Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 360 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдон Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/520 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн”-ий “Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газрын орлогч дарга” гэснийг “Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга” гэж, “Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга” гэснийг “Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн” гэж тус тус өөрчилсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020000907

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
...*02 дугаар* сарын ...*14*...-ны өдрийн
...*Н.Н.С. дугаар*... захирамжийн
1 дүгээр хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: -Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
- Гишүүд: -Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны орлогч дарга;
- Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Газар, хот байгуулалтын салбарын эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн барилга, орон сууцны бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;
- Төсөл хэрэгжүүлэх байршлын иргэний төлөөлөл (зөвшилцсөнөөр).
- Нарийн бичгийн дарга: -Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн.